

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Ашигт малтмал, газрын тосны газар

Газрын тос, бүтээгдэхүүний газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-3

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай-3, Засгийн газрын XII
байр, баруун жигүүр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

-

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хүлээсэн чиг үүрэг, тус хуулийг дагалдан гарсан журам, Засгийн газрын үйл ажиллагааны урт болон дунд хугацааны бодлого, хөтөлбөрт газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой тусгасан арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах хүрээнд нэгжүүдийн үйл ажиллагааг удирдаж, гүйцэтгэлийн үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцан, тайлагнана.

Албан тушаалын зорилт:

1. Газрын тосны салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, Улсын их хурал, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний талаарх бодлогыг хэрэгжүүлэх, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах стандарт, дүрэм, журам, зааврыг боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
2. Бүтээгдэхүүн хуваах гэрээ, эрлийн гэрээ байгуулах, газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлуулах ажлыг зохион байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг хянах, ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлэх, ашиглалтын талбайн хэмжээ, түүний хилийн заагийн булангийн цэгийн солбицлыг гэрээлэгчтэй харилцан тохиролцох, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь буцаан авах ажлыг зохион байгуулах, газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;
3. Хөрөнгө оруулалт, зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тосны тайланг хянах, газрын тосны борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох орлого, төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, хайгуул, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах, газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, хүлээн авах ажлыг зохион байгуулах;
4. Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүх төрлийн шатахуун, шатдаг хий импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгахтай холбогдуулан бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хийн барилга байгууламжид техник, технологийн дүгнэлт гаргах, хяналт тавих, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар санал боловсруулах, нийлүүлэгч талуудтай хийх уулзалт, хэлэлцээрт оролцох, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гадаад дотоод нөхцөл байдал, үлдэгдэл, нөөц, валютын ханшны өөрчлөлт, бөөний болон жижиглэнгийн үнийн хэлбэлзэлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;
5. Хууль тогтоомжид заасан бусад нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Газрын тос, уламжлалт бус газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний талаар УИХ, Засгийн газраас гаргасан бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;	Стандарт, норм, дүрэм, журмын хэрэгжилт хангагдсан байна.	Х
	3. Газрын тосны эрэл, хайгуул, орд ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны талаар мэргэжлийн санал дүгнэлт гаргах.	Мэргэжлийн санал, дүгнэлт гаргасан байна.	Х



2 дугаар зорилтын хүрээнд	1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайд захиалга хүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахад мэргэжлийн санал, дүгнэлтийг үндэслэн удирдан зохион байгуулах;	Санал, дүгнэлт нь үндэслэлтэй, хууль, журмын шаардлага хангасан байна.	Г, Х
	2.Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны гэрээ, хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах, хүчингүй болгох, газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон аливаа маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн санал, дүгнэлт гаргах;	Санал, дүгнэлт нь хуульд нийцсэн, судалгаа, нотолгоонд үндэслэсэн байна.	Г, Х
	3.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг судлан хянаж, санал дүгнэлт гаргах, байгууллагын даргаар батлуулах ажлыг зохион байгуулах;	Мэргэжлийн түвшинд судалгаа хийж, санал дүгнэлт гаргасан байна.	Г, Х
	4.Гэрээлэгч компанитай хийх жилийн уулзалтыг зохион байгуулах;	Гэрээлэгчтэй жилийн ажлын уулзалт хийсэн байна.	Г, Ш
	5.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалт, байгаль орчны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих, хайгуулын талбайд хамаарах орон нутаг, ард иргэдэд гэрээлэгч компаниудын үйл ажиллагааг сурталчлан таниулах;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Х, Ш
	6.Гэрээлэгч компанийн тухайн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээнд хийгдэж буй цооногийн өрөмдлөг, перфораци, туршилт, шингэн хагалбар, ус шахалт, дэд бүтцийн ажлууд болон түүхий тосны олборлолт, хэмжилт, хадгалалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулах;	Ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан байна.	Х, Ш
	7.Газрын тосны нээлтийн цооног, үр ашигтай нээлтийг бүртгэх, үнэлгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, Мэргэжлийн зөвлөл болон Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт, шийдвэр гаргуулах;	Бодлогын бичиг баримт, хуулийн шаардлагад нийцсэн байна.	Х, Ш
	8.Газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг хянах, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;	Тоо хэмжээ үнэн зөв баталгаажсан байна.	Г, Х
	9.Гэрээлэгч компанийн тухайн жилийн нэмэлт ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судлах, санал, дүгнэлт гаргах, батлуулах;	Мэргэжлийн санал, дүгнэлт гарсан байна.	Г, Х
	10.Газрын тосны ордын ашиглалтын талбайн хэмжээг Гэрээлэгч компанитай хэлэлцээ хийж, харилцан тохиролцож тогтоох;	Ашиглалтын талбайн хэмжээг тогтоосон байна.	Г, Х



	11.Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргаж, Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	Санал, дүгнэлт хүргүүлсэн байна.	Г, Х
	12.Ашиглалтын талбайн булангийн цэгүүдийг тогтоож, тэмдэглэгээ тавих ажлыг зохион байгуулах;	Тэмдэглэгээ хийгдсэн байна.	Г, Х, Ш
	13.Хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь буцаан авах ажлыг зохион байгуулах.	Ажлын хэсгийн дүгнэлт гарч, шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хянаж нэгтгэх, санхүүгийн шалгалт хийж дүгнэлт гаргах, газар дээр нь хяналт тавих;	Дүгнэлт нь хуульд нийцсэн, судалгаа, нотолгоонд үндэслэсэн байна.	Г, Х, Ш
	2.Газрын тостой холбоотой үйл ажиллагааны орлогыг тооцох, Засгийн газарт ногдох орлого, төлбөр, урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;	Тооцоолол үнэн зөв, баримт, үндэслэлтэй байна.	Г, Х
	3.Хайгуул, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах, шаардлагатай тайланг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;	Дүрмийн шаардлагад нийцсэн байна.	Х, Ш
	4.Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэх, хүлээн авах ажлыг зохион байгуулах.	Дүрмийн шаардлагад нийцсэн байна.	Г, Х
	5.Газрын тосны эрэл, хайгуул, орд ашиглалт, олборлолт, экспортын мэдээг өдөр, сар, улирлаар гаргаж, удирдлагыг мэдээллээр шуурхай хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Мэдээ тайлан хугацаандаа үнэн зөв, бодитой гарсан байна.	Х, Ш
	1.Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгахад шаардагдах техникийн дүгнэлт хянах;	Хууль, норм ба дүрэм, стандартын шаардлагад нийцсэн байна.	Х
	2.Шатахууны хэрэглээг евро стандарт руу шилжүүлэх шат дараалсан арга хэмжээ авах;	Чанартай шатахуунаар хангах бодлогыг хэрэгжүүлсэн байна.	Х
	3.Хэрэглэгчдийн зүгээс шатахууны чанарын талаар гаргасан санал, гомдлын дагуу хяналтын байгууллагатай хамтран үзлэг, шалгалт зохион байгуулах, холбогдох арга хэмжээ авах;	Үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангасан байна.	Х
	4.Дэлхийн зах зээлийн байдал, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, хилийн үнэ, валютын	Судалгааг үнэн зөв мэдээлэлд тулгуурлан хийсэн байна.	Х, Ш



4 дүгээр зорилтын хүрээнд	ханшны хөдөлгөөний судалгааг тухай бүр гаргах;			
	5.Хамтарсан үнийн зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, хуралдааныг зохион байгуулах, зөвлөлөөс гарсан зөвлөмжийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Шатахууны үнийн асуудлыг зохих түвшинд шийдвэрлэсэн байна.		Х, Г
	6.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтэд шатахууны хангамжийн талаар мэдээлэл өгөх;	Хангамжийн талаар нийтэд мэдээлэл өгсөн байна.		Г
	7.Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой, найдвартай хангах гэрээ, хэлцэл байгуулах, уулзалт зохион байгуулах;	Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг хангах гэрээ хэлцэл байгуулсан байна.		Г
	8.Газрын тосны бүтээгдэхүүний импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бусад боомтуудаар импортлох боломжийг судлах, хангамжийн нөхцөл байдал, хэтийн төлөвийн талаар судалгаа хийх;	Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангасан байна.		Х
	9.Газрын тосны бүтээгдэхүүний талаар гэрээлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний нөхцөл, бусад асуудлаар санал боловсруулах;	Жил бүр уулзалт зохион байгуулсан байна.		Г
	10.Газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц бүрдүүлэх, сэлгэх, хадгалах, шилжүүлэх, гэрээ хэлцэл байгуулах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Улсын болон компанийн нөөц бүрдүүлсэн байна.		Х
	11.Газрын тосны бүтээгдэхүүний аж ахуйн нэгжийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай тооцоо судалгааг холбогдох байгууллагад хүргүүлэх, холбогдох журмын дагуу мэдээ, мэдээллийг боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах;	Цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр хангасан байна.		Х
	12.Газрын тосны бүтээгдэхүүний мэдээг өдөр, сар, улирлаар гаргаж, удирдлагыг мэдээллээр шуурхай хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Мэдээ тайлан хугацаандаа үнэн зөв, бодитой гарсан байна.		Х, Ш
	1.Хэлтсүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, баталгаажуулахад хяналт тавих;	Албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан байна.		Г, Х
	2.Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг албан тушаалын тодорхойлолтод заасан үйл ажиллагааны дагуу гүйцэтгүүлэх, биелэлтэд хяналт тавих;	Мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа тогтмол хэвийн явагдаж, төлөвлөгөөт ажлууд нь бүрэн хэрэгжсэн байна.		Г, Х



5 дугаар зорилтын хүрээнд	3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу өгөх, хянах арга хэмжээ авах;	Хянаж, шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	X
	4.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, гүйцэтгэлийн тайланг хагас болон бүтэн жилээр гаргах, хянах, үнэлгээ хийх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	Г, X
	5.Төрийн жинхэнэ албан хаагчийн "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ийг хуулийн хугацаанд гаргах;	Мэдүүлэг	Г
	6.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомжийн хүрээнд биелүүлэх, мэдээ мэдээллээр хангах;	Үүрэг даалгавар, биелэлт, мэдээ мэдээлэл	Г, X
	7.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэн ажиллах.	Шийдвэрийн биелэлт	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - газрын тосны инженерчлэл /072406/; - менежемент ба удирдахуй /0413/. 	
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> - Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх; - Тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх. 	
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - хариуцсан газрын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; - газрын үйл ажиллагааг байгууллагын болон бусад нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах; - байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - байгууллагын үйл ажиллагааны чиглэл, стратегийг тодорхойлох; - албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийн зөрүүг арилгахад туслах, зөвлөх, чиглүүлэх, шаардлага тавих; - байгууллагын албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, адил тэгш хандах; - байгууллагын албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг бүрэн дайчлах; - байгууллагын үйл ажиллагаа дахь эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, авах арга хэмжээний төслийг боловсруулах, танилцуулах; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих, сөргөлдөөн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;



	<ul style="list-style-type: none"> - ашиг сонирхлын зөрчилгүй байж, үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - бусад.
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - аливаа асуудлын талаар бүрэн ойлголт авахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүгнэлт хийх; - хоорондоо шууд хамааралгүй нөхцөл байдлын байж болох уялдаа холбоог тодорхойлдог байх; - болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөдөг байх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн дүн шинжилгээ хийх; - судалгаанаас гарсан үр дүнг тухайн сэдвээр өмнө хийсэн судалгааны ажлын үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан санал, бодлогын зөвлөмж боловсруулах; - бодлогын болон эрх зүйн үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарын эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль тогтоомжийн төсөлд тусгах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгадаг байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
Манлайлах	<ul style="list-style-type: none"> - ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; - байгууллагын үйл ажиллагаанд шинэлэг санаа дэвшилтэт арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - харилцааны өндөр соёлтой байх; - эрх зүйн чадамжтай, өөрийнхөө үйлдлийг ухамсарлах чадвартай байх; - зөрчилдөөнийг эв дүйгээр зохицуулах; - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - нээлттэй, шударга байх; - хувийн зохион байгуулалт сайтай, цаг баримтлах; - бусад.
Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - компьютерын хэрэглээний программыг эзэмшиж, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн ажиллах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;



	<ul style="list-style-type: none"> - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах; - бусадтай нээлттэй, үнэнч шударга, чин сэтгэлээсээ, алагчлалгүй харьцан төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх; - бусад.
--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ:

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Ашигт малтмал, газрын тосны газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Хэлтсийн дарга – 3
- Ахлах мэргэжилтэн - 6
- Мэргэжилтэн - 30

Нийт: 39

Бусад харилцах субъект:

1. Яамд;
2. Засгийн газрын агентлагууд;
3. Бусад төрийн байгууллагууд;
4. Аж ахуйн нэгж.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА, АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

...../Г.МӨНХСАЙХАН/

20...оны ... дүгээр сарын ... -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 23 05 10

Дугаар: 177

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.09.28

Дугаар: А/133

(тамга/тэмдэг)

ДАРГА/Л.БАЯРМАНДАЛ/

2023 оны 09 дугаар сарын 28 -ны өдөр

